

**МОНГОЛ- ТӨВДИЙН ХАРИЛЦААНЫ ТАЛААР Ю.Н.РЕРИХИЙН
БИЧСЭН ӨГҮҮЛЛҮҮДИЙН ТУХАЙ**

Д.Бүрнээ¹

Миний бие оросын нэрт монголч бөгөөд төвдөч эрдэмтэн Ю.Н.Рерихийн \1902-1960\ Монгол-Төвдийн харилцааны талаар бичсэн “XIII-XIV-р зууны Монгол- Төвдийн харилцаа”, “XVI ба XVII зууны эхэн үеийн Монгол Төвдийн харилцаа” хэмээх хоёр өгүүллийг нэрт эрдэмтэний мэндэлсний 100 жилийн ойд зориулан хэдэн жилийн өмнө орос хэлнээс орчуулж нийтлүүлсэн билээ².

“XIII-XIV-р зууны Монгол-Төвдийн харилцаа” хэмээх өгүүлэл 1958 онд³, харин “XVI ба XVII зууны эхэн үеийн Монгол-Төвдийн харилцаа”⁴ хэмээх өгүүлэл нь 1959 онд тус тус хэвлэгдсэн болно⁵.

XIII-XIV-р зууны Монгол-Төвдийн харилцааны талаар бичихдээ Ю.Н.Рерих олон сурвалж бичгийг эш үндэс болгожээ. Үүнд “Юань улсын судар” хэмээх хятад сурвалжаас гадна монгол, төвд сурвалжуудыг ашигласан байна. Төвд сурвалж бичгээс төвдийн эрдэмтэн Гунгаадоржийн “Дэвтэр марбо” буюу “Улаан дэвтэр”, Шонубалын “Дэвтэр онбо” буюу “Хөх дэвтэр”, Сажагийн ёсны лам нарын бичсэн “Сажа габум”, “Сажа дунрав”, Сүмбэ хамба Ишбалжирийн “Хорчойнжүн” \монголд бурханы шашин дэлгэрсэн тухай өгүүлсэн сурвалж бичгийн төвд нэр Д.Б.\, намтар зохиолууд, монгол сурвалжаас Саган сэцэний “Эрдэнийн товч”-ийг ашиглажээ.

“XIII-XIV-р зууны Монгол-Төвдийн харилцаа” хэмээх өгүүлэлдээ эн тэргүүн монголын эзэнт гүрэн байгуулагдахаас өмнө Монгол, Төвдийн харилцаа ямархуу байсныг авч үзэхийг зорьсон байна. Ю.Н.Рерихийн бичсэнээр монголын эртний хүчирхэг овог аймгийн нэг болох хэрээд аймгийн дотор төвд хэргэм цолтой хүн байжээ. Тухайлбал Жаагамба хэмээх хүний нэрийн “гамбо” бол “улсын зөвлөх, ахлагч” гэсэн төвд үг бөгөөд тэр үеийн монгол хэлэнд энэ мэтийн төвд үг орсон нь хоёр орны хооронд харилцаа холбоо нэгэнт тогтсоныг харуулах баримт болж буйг дурджээ. Тэр

¹ МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

² Ю.Н.Рерих, XIII-XIV зууны Монгол-Төвдийн харилцаа: Bulletin, The IAMS News Information on Mongol Studies, 2001, No. 1 (27), No. 2 (28), 5-18-р тал., XVI ба XVII зууны эхэн үеийн Монгол- Төвдийн харилцаа, Bulletin, The IAMS News Information on Mongol Studies, 2002, No. 1 (29), No. 2 (30), 52-60-р тал.

³ Филология и история монгольских народов \Памяти Б.Я.Владимирцова\, М.: ИВЛ, 1958.,

⁴ Учёные записки Института Востоковедения АН СССР М., 1959. Т. XXIV (Монгольский сборник)

⁵ Энэ хоёр өгүүлэлийг дараах номд дахин хэвлэжээ: Ю.Рерих, Тибет и Центральная Азия, статьи, лекции, переводы, Самара, 1999. Монголо- тибетские отношения в XIII и XIV вв., 140-153-р тал, Монголо- тибетские отношения в XVI и начале XVII вв. 153-164-р талд буй.

үеэс Монгол, Төвдийн хооронд улс төр, эдийн засгийн харилцаа холбоо тогтох эхлэл тавигдсан бөгөөд Тангад буюу Си Ся улс, Монгол, Төвдийн хооронд харилцаа холбоо тогтоход тодорхой хэмжээгээр нөлөө үзүүлжээ. Монголчууд Тангадын нутагт удаа дараа довтлон орж байсан явдал төвдүүдийг түгшүүлж улмаар тэд хүчирхэгжин гарч ирсэн монголчуудтай нөхөрсөг харилцаа холбоо тогтоохыг эрмэлзэх болжээ.

Монгол, Төвдийн хооронд харилцаа холбоо тогтоход хоёр талын ашиг сонирхол нөлөөлсөн явдал зүйн хэрэг юм. Үүнд монголын талаас эзэнт гүрнийхээ хүрээг тэлэх, төвдийн талаас монголчуудын сүр хүчийг өөрсдийн улс төрийн зорилгод ашиглах гэсэн сонирхол байжээ.

Өгөдэйн хүү Годан ханы эзэмшилд төвдийн хил хязгаарын нутаг дэвсгэр багтаж байв. Ю.Н.Рерихийн бичсэнээр “Монголын цэргийн анги хилийн бүх зурвасын дагуу байрлаж байсан бөгөөд тун удалгүй төвдийн нутгийг эзэнт улсад нийлүүлэх тухай асуудал гарч иржээ”. Годан ханы Дорд дарханаар удирдуулсан цэргийн анги Төвдөд нэвтрэн орж ирсэн бөгөөд тэд төвдийн тухайн үеийн хамгийн нэр нөлөө бүхий хийд болох Сажа болон түүний тэргүүн Сажа бандид Гунгаажалцангийн талаар Годан ханд мэдээлжээ. Годан хан Сажа бандидыг өргөөндөө урин залсан бөгөөд түүний урилгыг хүлээн авсан тухайд “Сажа бандид урилгыг хүлээн авахдаа хийдийнхээ нэр нөлөөг өсгөх боломжийг олж харсан байж болзошгүй” гэж Ю.Н.Рерих бичжээ. Монголын хан, Төвдийн эрдэмтэн лам Сажа бандид нар Ланжуугийн ойролцоо байх Годан ханы өргөөнд уулзсан нь монгол төвдийн харилцаанд хожим “чод ён” \тө. chod yon\ буюу лам ба өглөгийн эзний харилцаа тогтохын эхлэл болсон байна. “Уг хэлэлцээр ёсоор төвдийн хараат байдлыг эзэнт улсын тэргүүний тухайд шавь ба гэрээ хэлэлцээр хийж буй шашны ламын засаглалын хувьд өглөгийн эзэн хэмээн ойлгож байсан бөгөөд үүгээрээ ламын засаглал төрийн эрх баригчдаас эрхэм болохыг онцлож” байжээ. Монгол Төвдийн харилцаанд Сажа бандид Гунгаажалцангийн дараа чухал үүрэг гүйцэтгэсэн хүн бол түүний ач Пагва лам Лодойжалцан болно. Тэр бээр Хубилай хааны дэргэд хааны багшаар олон жил сууж, эзэн хааны ордны хүрээнд бурханы шашныг дэлгэрүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэжээ. Хубилай хааны дэмжлэгтэйгээр Пагва лам эрх мэдлээ батжуулан Төвдийн арван гурван мужийн тэргүүнээр суув. XIII- XIV-р зууны үед Төвдийн Сажа хийдийн нэр нөлөө их байсан ба нөгөөтэйгүүр Сажа хийд бол “монголчуудаас төвдийг хянаж байсан улс төрийн захиргааны төв” байсан бөгөөд монголчууд сажийн ёсны тэргүүн лам Сажа бандид Гунгаажалцан болон Пагва лам Лодойжалцан нараар дамжуулан төвдийг эрхшээн захирч байжээ. Энэ үед төвдийн шашны бусад чиглэл, тухайлбал гармавын шашны лам нарыг урин залж байсан боловч тэдний дунд “алдартай хүн цөөн байсан” учир тусгайлан өгүүлсэнгүй хэмээн Ю.Н.Рерих тэмдэглэжээ. Төвдийн улс төр, эдийн засгийн амьдралын төв нь нөлөө бүхий сүм хийд байсан учир монголчууд төвдийн төр засаг тулгуурлаж байсан томхон сүм хийдийн тэргүүн нартай харилцаа холбоо тогтоож гэрээ хэлэлцээр хийж байжээ.

“XVI ба XVII зууны эхэн үеийн Монгол- Төвдийн харилцаа” хэмээх өгүүлэлдээ энэ үеийн Монгол, Төвдийн нийгэм улс төрийн онцлог байдал, Монгол, Төвдийн харилцаанд чухал үүрэг гүйцэтгэсэн шашин төрийн зүтгэлтнүүдийн үйл ажиллагааны талаар өгүүлжээ. Энэ үед Төвдөд шашны нөлөө хүчтэй хэвээрээ байсан тул төрийн хар феодалууд нь Юань улсын үеэс тус оронд их үүрэг гүйцэтгэж байсан сүм хийдүүдийг тойрон хүрээлж байв. Шашны олон урсгалуудын дотроос гэлүмба урсгалын нэр нөлөө өсөж, тус шашны тэргүүн Соднамжамц Төвдийн нийгэмд өөрийн шашны эзлэх байр суурийг бэхжүүлэхийн тулд гаднаас тухайлбал Монгол болон Хятадаас холбоотныг

эрж хайх болжээ. Ю.Н.Рерих Төвдийн төр шашны тэргүүн болох Далай лам нарын тэргүүлэх байх суурь тухайлан Гуравдугаар Далай лам Соднамжамц болон Тавдугаар Далай лам Лувсанжамцын үед монголын хаад болох Алтан гэгээн хаан болон хошуудын Гүүш хааны дэмжлэгтэй бэхжиснийг онцлон тэмдэглэжээ. Ялангуяа Гуравдугаар Далай лам Содномжамцын гэлүмба урсгалын улс төрийн байр суурийг бэхжүүлэхийн төлөө хийсэн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй өгүүлжээ. Төвдийн гэлүмба шашны тэргүүн, харилцаа холбоо тогтооход геополитикийн талаас хамгийн ойр байсан монголын Алтан хаантай хэрхэн холбоо тогтоож, гэрээ хэлэлцээр хийсэн талаар Гуравдугаар Далай ламын намтар, Сүмбэ хамба Ишбалжирын “Багсамжонсан”, Туган Дарамбазарын “Дунта”, монгол лам нарын бичсэн “Хорчойнжүн” зэрэг төвд сурвалж бичиг, Саган сэцэний “Эрдэнийн товч”, “Алтан товч” зэрэг монгол хэлээр уламжилж ирсэн сурвалж бичгийн мэдээнд тулгуурлан дэлгэрэнгүй өгүүлжээ. Төвдийн Далай лам шашны төдийгүй улс төрийн зүтгэлтний хувиар монголын Алтан хаан болон түүний залгамжлагчидтай гэрээ хэлэлцээр хийснээр “Монголд бурханы шашин ирээдүйд ноёрхох үндсийг тавьсан” байна. “Энэ үеэс эхлэн монголын ноёд ч гэлүмба урсгалыг ивээн тэтгэх болж, гэлүмбагийн байр суурь, нэр нөлөөнд аюул занал тохиолдох бүрийд монголын феодалуудаас тусламж эрж байсан” хэмээн Ю.Н.Рерих бичжээ. XIII- XIV зууны үед тогтсон бөгөөд “чод ён” хэмээх нэр томъёогоор илэрхийлж байсан гэрээт харилцаа нь XVI-XVII зууны үед “шашны эзэн өөрийн нэр хүндээр төрийн захирагчийн байр суурийг ариусган гийгүүлж, харин төрийн эзэн шашны тэргүүнийг ивээлдээ авч эрх ашгийг нь хамгаална” гэсэн утгатай монгол төвдийн эрх баригчдын хоорондын холбоо болон тогтсон байна.

Эцэст нь хэлэхэд Ю.Н.Рерих эдгээр өгүүлэлдээ төвд хэлээрхи сурвалжууд нь Монгол, Төвдийн төдийгүй Азийн улс орнуудын түүхийг судлахад чухал хэрэглэгдэхүүн болохыг тэмдэглэжээ.

Ю.Н.Рерихийн “XIII- XIV-р зууны Монгол- Төвдийн харилцаа”, “XVI зуун болон XVII зууны эхэн үеийн Монгол- Төвдийн харилцаа” хэмээх өгүүллүүд нь XIII- XIV, XVI ба XVII зууны эхэн үеийн Монгол, Төвдийн харилцааны асуудлыг судлахад чухал гарын авлага болох бүтээл юм. Төвд хэлээрхи сурвалжууд үүний дотроос монголчуудын төвд хэлээр бичсэн сурвалж, монгол хэлээрхи сурвалж тэргүүтнийг ашигласны хувьд өнөө үед ч эдгээр өгүүлэл үнэ цэнэтэй хэрэглэгдэхүүн хэвээр байгаа юм.

XIII-XIV зуун, XVI-XVII зууны Монгол-Төвдийн харилцааны талаар эрдэмтэн Ю.Н.Рерихийн судалгаандаа ашигласан сурвалж бичгүүдээс гадна дурдсан үе болон түүнээс хойшхи үеийн Монгол-Төвдийн харилцаанд холбогдох бусад сурвалж бичиг болон архивын хэрэглэгдэхүүнийг цаашид нарийвчлан судлах хэрэгтэй.